35

БАТЛАВ
БАГАНУУР ДҮҮРГИЙН ЗАСАГ
ДАРГА С.ДАВААСҮРЭН

2024 оны 11 дүгээр сарын 04

БАГАНУУР ХОТЫН ГЭР ХОРООЛЛЫН ИНЖЕНЕРИЙН ДЭД БҮТЦИЙН
ЗУРАГ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ ДААЛГАВАР

2024 оны 11 дүгээр сарын 01 №ЗД-16 Багануур дүүрэг

1	Боловсруулах үндэслэл, зорилго	**Боловсруулах үндэслэл:** - "Алсын хараа-2050" Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого - "Шинэ сэргэлтийн бодлого" хөтөлбөр - "2024 оныг "Бүсчилсэн хөгжлийг дэмжих жил" болгон зарлах тухай" Монгол улсын Засгийн газрын 2023 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 481 дугаар тогтоол - Монгол улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр - "Бүсчилсэн хөгжлийг дэмжих бүтээн байгуулалтын төслүүдийн техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв (Улсын хэмжээнд)"-ийн хүрээнд 2024 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалт; **Зорилго:** - Монгол улсын Засгийн газрын 2017 оны 347 дугаар тогтоолоор баталсан "Багануурын 2030 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө"-г хэрэгжүүлэх - Тухайн нэгж хэсгийн гэр хорооллын хүн амын эрүүл, аюулгүй амьдрах орчин бүхий орон зайн төлөвлөлтийг дэд бүтцийн хамт бий болгон хөгжүүлэх;
2	Байршил, эдийн засаг нийгмийн хөгжлийн байдал,	Тус дүүргийн 4 дүгээр хорооны Жаргалант хэсэг нь гэр хорооллын 361 өрх, 1120 хүн амтай, УДДТ-8-аас 1, 2, 3 дүгээр гудамжны 20 гаруй айл өрх ус, дулаанаар хангагдаж байна. 5 дугаар хорооны Нарийн хэсэг нь гэр хорооллын 731 өрх, 2500 хүн амтай, УДДТ-3-аас 1-4-р гудамжны 28 ус, дулаанаар хангагдаж байна. Эдгээр 2 хэсгийн үлдсэн айл өрхүүдийг ус, дулаанаар хангах УДДТ бүхий магистраль шугам сүлжээний зураг төслийг боловсруулна.
3	Хамрах хүрээ, газар нутгийн хэмжээ (га), хүн ам	**Газар нутгийн хэмжээ буюу төлөвлөлтийн хязгаар:** - Багануур дүүргийн 4 дүгээр хорооны Жаргалант хэсгийн 18,87 га талбайд (нэгж талбарын тоо 296, талбайн хэмжээ 188777 м^2); - 5 дугаар хорооны Рашаант хэсгийн 44,93 га талбайд (нэгж талбарын тоо 701, талбайн хэмжээ 449,322 м^2) тус тус төлөвлөлтийн хязгаарыг тогтооно. **Хамрах хүрээ:**

Бүртгэлийн дугаар
БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН
ҮНДЭСНИЙ ХУРЭЭ ТЕХНИК ЭДИЙН ЗАСГИЙН
ХУУЛБАР ОЛГОХ ... ЭЗГ
2025 оны 03 17 ... ер

		- Төлөвлөлтийн хязгаараас эргэн тойрон 1 км зайд төлөвлөлтийг хамруулан уялдуулах (төлөвлөлтийн хязгаар, хамрах хүрээг дүүргийн ГЗБА-наас авна) **Хүн ам:** - "Багануурын 2030 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө"-нд 2030 онд дүүргийн төвд нийт 60000 хүн оршин суухаар тооцсоноос 6000 нь гэр хороололд, 36000 нь нийтийн орон сууцанд, 18000 нь хувийн сууцанд оршин суухаар төлөвлөсөн байна. - Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөгөөр 2050 оны түвшинд хүн ам, өрхийг тодорхойлно.
4	Боловсруулах ажлын үе шат	- Судалгаа, үнэлгээ - Төлөвлөлт, тооцоолол
5	Боловсруулахад ашиглах материал	**Монгол Улсын хуулиуд:** - Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай; - Газрын тухай хууль; - Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль; - Барилгын тухай хууль; /шинэчилсэн найруулга/ - Орон сууцны тухай хууль; - Эрчим хүчний тухай хууль; - Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль; - Хот байгуулалтын тухай хууль; - Хот суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хууль; - Геодези, зураг зүйн тухай хууль; - Авто замын тухай хууль; /шинэчилсэн найруулга/ - Усны тухай хууль; - Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль; - Бусад холбогдох хуулиуд **Төсөл, хөтөлбөрүүд:** - Нийслэл Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлага; - Засгийн газрын 2017 оны 347 дугаар тогтоолоор батлагдсан "Багануурын 2030 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө" - Гадаад дотоодын хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй төсөл; **Норм, нормативууд:** - Хот, тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм (БНбД 30-01-04); - Хот, суурины дэвсгэр газарт хот байгуулалтын иж бүрэн үнэлгээ өгөх аргачилсан заавар (УББ 30-201-09); - Хот суурины хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах аргачилсан заавар (УББ 11-202-00); - Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг шинэчлэн боловсруулахдаа "1:500, 1000, 2000, 5000-ны масштабтай байр зүйн дэвсгэр зураглалын ажил" БД-11-106-08 болон "Инженерийн шугам сүлжээний зураглалын ажил" БД-11-105-06-ыг үндэслэн байр зүйн зургийн тодруулалт хийсэн дэвсгэр зураг ашиглах;

		- Барилга байгууламжийн инженер-экологийн судалгаа БД 11-102-07 - Хот суурины гудамж, талбайн төлөвлөлт (БНбД 32-04-06); - Зураг төслийн ажлын жишиг үнэ (БД 30-01-04); - Барилга, байгууламжийн буурь, суурийн зураг төсөл зохиох (БНбД 50-01-16); - Барилгын газар шороо ба буурь, суурийн ажил (БНбД 50-02-17); - Цутгамал бетон, төмөр бетон бүтээц (БНбД 52-02-05); - Цутгамал төмөр бетон бүтээцийн зураг төсөл зохиох заавар (БНбД 52-102-04); - Гадна дулаан хангамж БНбД (41-02-13); - Усан хангамж. Гадна сүлжээ ба байгууламж БНбД (40-02-06); - Ариутгах татуурга. Гадна сүлжээ ба байгууламж (БНбД 40-01-14); - Усан хангамж, бохир ус, гадна шугам сүлжээ, түүний барилга байгууламж (БНбД3.05.04.90); - Усан хангамж, ариутгах татуургын сүлжээний хуванцар хоолойг төлөвлөх ба угсрах. Үндсэн журам (БД 40-102-06) - Барилга доторхи ус хангамж, ариутгах татуурга (БНбД 40-05-16); - Дотор сантехникийн систем (БНбД 40-06-16); - Ариутгах татуургын сүлжээний хуванцар хоолойг төлөвлөх ба угсрах. Үндсэн журам (БД 40-102-06); - Цахилгаан байгууламжийн дүрэм (БД 43-101-03); - Автоматжуулалтын систем (БНбД 3.05.07-90); - Цахилгаан байгууламжийн дүрэм. Бүлэг 1,6 “Газардуулга ба цахилгааны аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээ” (БД 43-101-03*12); - Орон сууц, олон нийтийн барилгын цахилгаан төхөөрөмжийг төсөллөх ба угсрах (БД 43-102-07); - Хот тосгон ба суурин газрын гудамж талбай, зам талбайн гэрэлтүүлгийг төлөвлөх дүрэм (БД 30-102-11); - Хот тосгон ба суурин газрын гудамж талбай, зам талбайн гэрэлтүүлгийг төлөвлөх дүрэм (БД 30-102-11); - Барилга байгууламжийн галын аюулгүйн байдал (БНбД 21-01-02); - Барилга байгууламжийн зураг төсөл зохиох галын аюулгүйн норм (БНбД 21-02-02); - Барилга байгууламжийн гал унтраах автомат төхөөрөмж дохиоллын хэрэгсэл (БНбД 21-04-05); - Газар хөдлөлийн бичил мужлалын зураг ашиглах норм ба дүрэм (БНбД 22-04-16); - Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн амьдрах орчны шаардлагад нийцсэн зураг төсөл зохиох (БД 31-112-11); - Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, зөвшилцөх, магадлал хийх дүрэм - Бусад холбогдох норм, дүрэм, заавар **Холбогдох стандартууд:**

		- Хашаа, хайс, хашлагад тавигдах ерөнхий шаардлага, хэрэглээ UCS0001-02:2019 - Барилгын бүтээцийн материал /өргийн материал, бетон,арматур/ түүнд тавигдах ерөнхий шаардлага UCS 1501C:2020 - Явган хүний зам, талбайн төлөвлөлт, хучилт, угсралтад тавигдах шаардлага UCS 0901CB:2020 - Дүүргэгч материал UCS 1502C:2020 - Уур, ус тусгаарлагч материал UCS 1503C:2020 - Хаалга, цонх UCS 1504C:2020 - Дулаан, дуу чимээ тусгаарлах материалд тавигдах ерөнхий шаардлага UCS 1505C:2020 - Заслын материалд тавигдах ерөнхий шаардлага UCS 1506C:2020 - Халаалт агаар сэлгэлтийн материалд тавигдах ерөнхий шаардлага UCS 1507C : 2020 - Сантехникийн материалд тавигдах шаардлага UCS 1508C : 2020 - Нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайд байршуулах гэрэлтүүлгийн тоног төхөөрөмжид тавигдах шаардлага UCS 1901B:2020 - Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй дэд бүтцийн зураг төсөл UCS 1001C:2020 - Барилга, замын ажил гүйцэтгэх иргэдийн аюулгүй байдлыг хангах ерөнхий шаардлага UCS0001-01:2019 - Барилгын материалын стандартууд **Холбогдох дүрэм, журмууд:** - Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм (Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоол) - Барилгын захиалагчийн дүрэм (Засгийн газрын 2017 оны 170 дугаар тогтоол, 2018 оны 316 дугаар тогтоол нэмэлт, өөрчлөлт) - Барилгын ажилд зураг төсөл зохиогчийн хяналт тавих дүрэм (Барилга, хот байгуулалтын сайдын 2016 оны 178 дугаар тушаал) - Барилга байгууламжийн хувийн хэрэг хөтлөх журам (Барилга, хот байгуулалтын сайдын 2016 оны 180 дугаар тушаал) - Зөвлөх үйлчилгээ үзүүлэх иргэн, хуулийн этгээдэд тавих шаардлага, бүртгэх журам (Барилга, хот байгуулалтын сайдын 2018 оны 319 дүгээр тогтоол)
6	Баримт бичгийн бүрдэл	**БИЧИГЛЭЛИЙН МАТЕРИАЛ:** - Шинжилгээ судалгааны ажил хийхэд баримтлах арга зүйн нийтлэг зөвлөмж; - Инженер-геологийн дүгнэлт; - Хот байгуулалтын иж бүрэн үнэлгээ; - Судалгааны материал (иргэд оршин суугч, аж ахуй нэгж, төлөвлөлтийн бүсэд хийгдсэн судалгаа зэрэг бусад шаардлагатай материал); Төлөвлөлт: - Даалгаварт өгөгдсөн “инженерийн дэд бүтэц” болон “онцгой нөхцөл”-ийн дараалаар тайлбар бичиг бичих;

		- Төлөвлөлтийн шийдэл, эдийн засгийн тооцоо, хөрөнгө оруулалт, эх үүсвэр, хэрэгжүүлэх арга хэмжээг боловсруулах; **ЗУРАГЛАЛЫН МАТЕРИАЛ:** Судалгаа одоогийн байдал: - Байршлын схем М1:25000 - Орчны тойм М1:10000, М1:25000 - Дэвсгэр зураг М1:5000; - Барилгажилт М1:5000; - Хүн амын нягтрал М1:5000; - Барилгажилтын нягтрал М1:5000; - Дулаан хангамж М1:2000; - Усан хангамж, ариутгах татуурга М1:2000; - Цахилгаан хангамж М1:2000; - Холбоожуулалт М1:2000; - Инженерийн бэлтгэл арга хэмжээ өндөржилт, улаан шугам М1:2000; **Инженерийн хангамжийн нэгдсэн төлөвлөлт:** - Инженерийн шугам сүлжээний нэгдсэн төлөвлөлт М1:5000; - Инженерийн бэлтгэл арга хэмжээ /газрын доор/ М1:10000; - Өндөржилт М1:5000; - Дулаан хангамжийн төлөвлөлт М1:2000; - Усан хангамжийн шугам сүлжээний төлөвлөлт М1:2000; - Ариутгах татуургын шугам сүлжээний төлөвлөлт М1:2000; - Цахилгаан хангамжийн төлөвлөлт М1:2000; - Мэдээлэл, холбооны шугам сүлжээний төлөвлөлт М1:5000; - Хог хаягдлын менежментийн төлөвлөлт М1:10000;
7	Инженерийн дэд бүтцэд тавигдах шаардлага	**Дулаан хангамж:** - Уг 2 хэсгийн нийт дулааны эрчим хүчний одоо байгаа болон төлөвлөлтийн ачааллыг нарийвчлан тооцож, баланс гаргах - Нийт дулааны хэрэглээг төвлөрсөн дулаан хангамжийн системд холбох техникийн шийдлийг гаргаж, хангагч байгууллагатай зөвшилцөх, өргөтгөх, шинэчлэх шаардлагатай магистраль, өргөлтийн насос станцын тооцоог боловсруулж,төлөвлөлтөд тусгах - Халаалт, агаар сэлгэлтийг “Багануурын дулааны станц” ТӨХК-ийн 2024 оны ..... сарын ..... -ны өдрийн №..... дугаартай техникийн нөхцөлийг үндэслэн барилгын талбайн ойр орчмын инженерийн шугам сүлжээний нөхцөл байдалтай уялдуулж төлөвлөх; **Цахилгаан хангамж:** - Ус, дулаан дамжуулах төвийг 2 талын тэжээлтэй төвлөрсөн цахилгаан хангамжийн сүлжээнд холбох - Одоо байгаа цахилгааны шугамын ачаалал, ашиглалтын түвшинг тодорхойлох, шаардлагатай бол шугам сүлжээг өргөтгөх, шинэчлэх асуудлыг хангагч байгууллагатай зөвшилцөн төлөвлөх

		- Дүүргийн цаашид өсөн нэмэгдэх хэрэгцээ шаардлагыг харгалзан үзэж ажлыг төлөвлөн шугамын тооцоог хийх;
8	Онцгой нөхцөл	- Төлөвлөлтийн хязгаар, хамрах хүрээнд хийгдэж байгаа гэр хорооллын 2 хэсгийн дахин төлөвлөлтийн шийдлийг үе шатаар хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, хүрэх үр дүнг 5 жилийн давтамжаар тодорхойлох; - Инженерийн дэд бүтцийг байгаль цаг уурын онцлогт тохируулан дэвшилтэт техник, технологийн дагуу оновчтой төлөвлөх; - Байгаль орчныг хамгаалах, хөрс, ус, агаарын бохирдлыг бууруулах, усны дахин ашиглалт /саарал ус/-ыг нэмэгдүүлэх, хур тунадасны ус хуримтлуулах, газрын гадарга дээрх цэвэр усны нөөцийг ашиглах, усны хэрэглээг багасгах боломжит хувилбаруудыг боловсруулах; - Сэргээгдэх эрчим хүчийг ашиглах боломжийг судалж тусгах;
9	Боловсруулах хугацаа	Захиалагч гүйцэтгэгч талуудын хооронд гэрээ байгуулснаас хойш хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулах нийт хугацаа 150 хоног байна. Дээрх хугацаанд магадлал хийлгэх хугацаа ороогүй болно. Үүнээс: **Эхлэлийн тайлан: /60 хоногт гүйцэтгэнэ/** - Одоогийн байдлын иж бүрэн судалгаа хийсэн байх - Архитектур орон зайн төлөвлөлтийн шийдэл, бүсчлэл, гаргасан байх - Төлөвлөлтийн хязгаарт байрлаж байгаа төсөл, хөтөлбөр, төлөвлөлтөөр хийгдэж байгаа барилга байгууламжуудыг тусгасан зураглал, хүчин чадлыг тодорхойлсон байх **Дундын тайлан: /70 хоногт гүйцэтгэнэ/** - Эхлэлийн тайланд өгсөн саналыг тусгасан байх - Инженерийн шугам сүлжээ, төлөвлөлтийн замын сүлжээ, дэд бүтцийн хангамжийн шийдлийн дагуу төлөвлөлтийг гүйцэтгэсэн байх **Эцсийн тайлан: /20 хоногт гүйцэтгэнэ/** - Ерөнхий төлөвлөгөөнд холбогдох байгууллагаас өгсөн санал, дүгнэлтийг тусгаж эцсийн байдлаар хүлээлгэн өгөх **Магадлалын ерөнхий дүгнэлт:** - Эцсийн тайлан гарснаас хойш 30 хоногийн дотор Магадлалын ерөнхий дүгнэлт гаргуулан эцсийн тайлангийн хамт актаар хүлээлгэн өгнө.
10	Шаардагдах хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр	Улсын төсвийн 300,000,000 (гурван зуун сая) төгрөг;
11	Захиалагч байгууллага	Багануур дүүргийн Засаг даргын Тамгын газар;
12	Гүйцэтгэгч байгууллага	Барилга, хот байгуулалтын сайдын 2021 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн 147 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Барилга, байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилгын ажил гүйцэтгэх, барилгын материалын үйлдвэрлэл, өргөх

		- Гадна цахилгаан, дотор гэрэлтүүлэг, хүчит төхөөрөмжийн зураг төслийг "БЗӨБЦТС" ТӨХК-ийн 2024 оны ..... сарын ..... -ний өдрийн №..... дугаартай техникийн нөхцөлийг үндэслэн барилгын талбайн ойр орчмын инженерийн шугам сүлжээний нөхцөл байдалтай уялдуулж төлөвлөх; **Усан хангамж:** - Нэгдсэн ус хангамжийн сүлжээнд холбох - Одоо байгаа цэвэр усны шугамын ачаалал, ашиглалтын түвшинг тодорхойлох, шугам сүлжээг өргөтгөх, шинэчлэх асуудлыг хангагч байгууллагатай зөвшилцөн төлөвлөх - Ус хангамж, ариутгах татуургын системийг "Багануур-Ус" ААТҮГ-ын 2024 оны ..... сарын ..... -ны өдрийн №..... дугаартай техникийн нөхцөлийг үндэслэн барилгын талбайн ойр орчмын инженерийн шугам сүлжээний нөхцөл байдалтай уялдуулж төлөвлөх; **Ариутгах татуурга:** - Нэгдсэн ариутгах татуургын сүлжээнд холбох - Одоо байгаа ариутгах татуургын шугамын ачаалал, ашиглалтын түвшинг тодорхойлох, шугам сүлжээг өргөтгөх, шинэчлэх асуудлыг хангагч байгууллагатай зөвшилцөн төлөвлөх **Холбоо, мэдээлэл:** - Одоо байгаа худаг сувагчлалын байгууламжийн ачааллыг тооцох, шилэн кабелийн сүлжээ төлөвлөх - Дохиоллын хяналтын нэгдсэн систем төлөвлөх - Холбоо дохиоллын зураг төслийг боловсруулахад "Мэдээлэл холбооны сүлжээ" ТӨХХК-ийн Багануур дүүргийн газрын 2024 оны ..... сарын ..... -ний өдрийн №..... дугаартай техникийн нөхцөлийг үндэслэн барилгын талбайн ойр орчмын инженерийн шугам сүлжээний нөхцөл байдалтай уялдуулж төлөвлөх; **Хонгилын систем:** - Инженерийн шугам сүлжээний байгууламжийг газар доорх туннель /хонгил/-ийн системд байршуулах төлөвлөлтийн хувилбар, хөрөнгө оруулалтын харьцуулсан тооцоо боловсруулах **Ерөнхий шаардлага:** - Хангагч байгууллагуудаас холбогдох техникийн нөхцөлийг гаргуулж, түүний дагуу төвлөрсөн шугам сүлжээнд холбох, эсхүл бие даасан дэд төв байдлаар төлөвлөлтийг хийж зөвшилцөх; - Шаардлагатай тохиолдолд өөрийн эх үүсвэрээр (цахилгаан) хангах зураг төсөв боловсруулан холбогдох байгууллагуудаар зөвшилцөн батлуулах шаардлагатай. - Инженерийн шугам сүлжээний хамгаалалтын зурвас, холбогдох норм дүрэм, стандартыг баримтлан төлөвлөх; - Гадна шугам сүлжээний зураг төслийг мэргэжлийн байгууллагаар хянуулж, зөвшилцөх;

		байгууламж, түүний эд анги үйлдвэрлэл, угсралт, засвар, үйлчилгээ эрхлэх хуулийн этгээдэд тусгай зөвшөөрөл олгох, үйлчилгээний хөлс тогтоох, тэдгээрт хяналт тавих журам" ▪ 3Т-7.1 Ус хангамж, ариутгах татуургын гол (магистраль) шугам сүлжээ, түүнтэй холбогдох барилга байгууламжийн технологийн зураг төсөл ▪ 3Т-7.2 Дулааны бие даасан 5.0 МВт хүртэлх эх үүсвэрийн барилга байгууламжийн технологи, шугам сүлжээний зураг төсөл ▪ 3Т-7.3 Бага хүчин чадлын цахилгааны эх үүсвэр, (бие даасан болон сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэр) түүнтэй холбогдох шугам сүлжээ, барилга, байгууламжийн технологийн зураг төсөл ▪ 3Т-7.4 Мэдээлэл, харилцаа холбоо дохиоллын гол (магистраль) шугам сүлжээ, түүнтэй холбогдох барилга байгууламжийн технологийн зураг төсөл ▪ 3Т-9.2 Багаас дунд төвөгшилтэй бүх төрлийн барилга байгууламжид зориулсан инженер-геологийн судалгаа (инженер-геологийн нөхцөл харгалзахгүй) ▪ 3Т-10.2 Барилга байгууламжийн ажлын төсөв; тус тус тусгай зөвшөөрөл бүхий аж ахуй нэгж байгууллага байна.
13	Зөвшөөрөлцөх байгууллага	Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, инженерийн дэд бүтцийн шугам сүлжээний зураг төсөлд холбогдох байгууллагаас өгсөн санал, дүгнэлтийг тусгаж эцсийн байдлаар хүлээлгэн өгөх; (Холбогдох төрийн захиргааны төв байгууллага болон ашиглалтын байгууллагуудаас санал авна.) **1. Зөвшөөрөлцөх байгууллага** 1.1.Багануур дүүргийн Засаг даргын Тамгын газар; 1.2.Багануурын дулааны станц ТӨХК; 1.3.Багануур-Ус ААТҮГ; **2. Зөвшилцөх байгууллага** 2.1.Багануур дүүргийн Засаг даргын Тамгын газар; 2.2.Багануурын дулааны станц ТӨХК; 2.3.Багануур-Ус ААТҮГ; 2.4.БЗӨБЦТС ТӨХК 2.5."Мэдээлэл холбооны сүлжээ" ТӨХК-ийн Багануур дүүргийн газар

ХЯНАСАН:
БАГАНУУР ДҮҮРГИЙН МЕНЕЖЕР Б.БЯМБАЦЭЦЭГ

БОЛОВСРУУЛСАН:
ТОХИЖИЛТ, НИЙТИЙН АЖ АХУЙН
ХЭЛТСИЙН ХОТ БАЙГУУЛАЛТ, БАРИЛГА,
ОРОН СУУЦ ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН Б.МӨНХЧИМЭГ